



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A/27

Мөрөн сум

**Хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.10, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 88 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үндсэн хөрөнгө төлөвлөх, олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 3 нэр төрлийн 371,553,750.13 (Гурван зуун далан нэгэн сая таван зуун тавин гурван мянга долоон зуун тавин төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн балансын үлдэх өртөгтэй шилжүүлэх тээврийн хэрэгслийг хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурьдсан арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосугай.

2.1 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгах;

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Бэхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ПҮРЭВДОРЖ

6712010033

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 1827 дугаар захирамжийн хавсралт

а/ Шилжүүлэх тээврийн хэрэгслийн жагсаалт

| №   | Аймаг, сумын нэр | Байгууллагын нэр                          | Хөрөнгийн нэр                          | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Балансын үнэ /төг/ | Байгуулсан элэгдэл /төг/ | Үлдэгдэл үнэ /мян. төг/ | ОНӨГ-ын үнийн санал /төг/             | Аймгийн ИТХ-ын шийдвэр /төг/          |
|-----|------------------|-------------------------------------------|----------------------------------------|----------------------|-------------|------------|--------------------|--------------------------|-------------------------|---------------------------------------|---------------------------------------|
| 1   | Баянзүрх         | Баянзүрх сумын Засаг даргын Тамгын газар  | GDLG 956 ковш автомашин                | 2022                 | ш           | 1          | 149,800,000.00     | 42,443,333.22            | 107,356,666.78          | "Шилгэдийн Харгуй" ОНӨХХК-д шилжүүлэх | "Шилгэдийн Харгуй" ОНӨХХК-д шилжүүлэх |
| 2   | Баянзүрх         | Баянзүрх сумын Засаг даргын Тамгын газар  | Komatsu pc 240 lc экскаватор автомашин | 2023                 | ш           | 1          | 198,000,000.00     | 59,400,000.00            | 138,600,000.00          | "Шилгэдийн Харгуй" ОНӨХХК-д шилжүүлэх | "Шилгэдийн Харгуй" ОНӨХХК-д шилжүүлэх |
| 3   | Улаан-Уул        | Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар | GR 180 автогрейдер автомашин           | 2023                 | ш           | 1          | 134,970,000.00     | 9,372,916.65             | 125,597,083.35          | "Шилгэдийн Харгуй" ОНӨХХК-д шилжүүлэх | "Шилгэдийн Харгуй" ОНӨХХК-д шилжүүлэх |
| Дүн |                  |                                           |                                        |                      |             |            | 482,770,000.00     | 111,216,249.87           | 371,553,750.13          |                                       |                                       |

ооо